

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Цагаан эрэг тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/06/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 99025338 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	2-3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	4-8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9-12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.2 Албан шаардлага	16
5.1 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ЦАГААН ЭРЭГ ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Т.ШИНЭБАЯР ТАНАА

2024.03.15 № ЦЭА-2024/06/НА-СТА-ОНА
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь тайлант онд 870,698.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,991,613.8 мянган төгрөгийн зардал гарган 1,120,915.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Алдагдал нь үндсэн үйл ажиллагааны үр дүнгээр бус үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас голлон шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

2023 оны 04 дүгээр сард тус байгууллагын автограшт гарсан гал түймрийн улмаас 3 автомашин шатаж, сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээнд 15,800.0 мянган төгрөгийн төлөвлөгдөөгүй зардал гарч, гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэхээр аймгийн Цагдаагийн газар болон Прокурорын байгууллагад хандсан боловч гэмт хэргийн шинжтэй үйлдэл биш гэж үзэж, хохирлын хэмжээг тогтоогоогүй байна.

СЭА-2024/06/НА-СТА-ОНА

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 80.3 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2022 оны12-р сарын 31	2023 оны12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	97,245,742.55	122,969,316.87
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	416,755.55	1,221,510.87
1.1.2	Дансны авлага	15,478,407.00	19,976,453.00
1.1.3	Татвар, НДШ-ын авлага	-	-
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бараа материал	81,350,580.00	101,771,353.00
1.1.6	Урьдчилж төлсөн зардал \ тооцоо\	0	0
1.2	Эргэлтийн хөрөнгийн дүн	97,246,012.55	122,969,316.87
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,880,372,610.63	1,929,653,977.61
1.2.2	Биет бус хөрөнгө	116,586,852.23	454,306.77
1.2.10	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,996,959,462.86	1,930,108,284.38
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,094,205,475.41	2,053,077,601.25
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	15,104,778.43	23,209,082.75
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	2,704,171.48	9,798,872.23
2.1.1.4	НДШ- ийн өглөг	13,457,116.37	
2.1.1.7	Ноогдол ашгийн өглөг		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	31,266,066.28	33,007,954.98
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	31,266,066.28	33,007,954.98
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч -төрийн		
2.3.6	Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	3,987,720,109.39	3,987,720,109.39
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(924,780,970.26)	(1,967,650,463.12)
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,062,939,139.13	2,020,069,646.27
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,094,205,205.41	2,053,077,601.25

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны12-р сарын 31	2023 оны12-р сарын 31
I	Үйл ажиллагааны орлогын дүн	1,184,269,923.00	870,698,700.00
12	Татварын бус орлого	627,470,223.00	24,868,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	627,470,223.00	24,868,500.00
120010	Борлуулалтын орлого/ цэвэр/	627,470,223.00	24,868,500.00
13	Тусламж, санхүүжилтийн орлого	556,799,700.00	845,830,200.00
1330	Төсвийн захирагчдаас	556,799,700.00	845,830,200.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	556,799,700.00	845,830,200.00
II	Үйл ажиллагааны зардлын дүн	2,109,050,893.26	1,991,613,831.92
21	Урсгал зардал	2,109,050,893.26	1,991,613,831.92
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	2,109,050,893.26	1,991,613,831.92
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	589,691,175.80	864,104,591.68
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	589,691,175.80	864,104,591.68
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,519,359,717.46	1,127,509,240.24
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,519,359,717.46	1,127,509,240.24
III	Үйл ажиллагааны үр дүн	(924,780,970.26)	(1,120,915,131.92)
	Татвар төлөхийн өмнөх ашиг/ алдагдал /	(924,780,970.26)	(1,120,915,131.92)
	Орлогын татварын зардал		
	Татварын дараах ашиг / алдагдал/	(924,780,970.26)	(1,120,915,131.92)
	Тайлант үеийн цэвэр ашиг / алдагдал/	(924,780,970.26)	(1,120,915,131.92)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,987,720,109.39	0.00	0.00	(924,780,970.26)	3,062,939,139.13
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	0.00	0.00	-	-
3	Залруулсан үлдэгдэл	3,987,720,109.39	0.00	0.00	(924,780,970.26)	3,062,939,139.13
4	Тайлант үеийн цэвэр ашиг/ алдагдал/	0.00	0.00	0.00	-	0.00
5	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,987,720,109.39	0.00	0.00	(924,780,970.26)	3,062,939,139.13
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	0.00	0.00	78,045,639.06	78,045,639.06
7	Залруулсан үлдэгдэл	3,987,720,109.39	0.00	0.00	(846,735,331.20)	3,140,984,778.19
8	Тайлант үеийн цэвэр ашиг/ алдагдал/	0.00	0.00	0.00	(1,120,915,131.92)	(1,120,915,131.92)
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,987,720,109.39	0.00	0.00	(1,967,650,463.12)	2,020,069,646.27

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	576,680,683.00	972,246,189.01
12	Татварын бус орлого	19,880,983.00	126,415,989.01
120	Нийтлэг татварын бус орлого	19,880,983.00	126,415,989.01
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	19,880,983.00	126,415,989.01
13	Тусламж, санхүүжилтийн орлого	556,799,700.00	845,830,200.00
1330	Төсвийн захирагчдаас	556,799,700.00	845,830,200.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	556,799,700.00	845,830,200.00

1.2	Мөнгөн зарлагын дүн/-/	588,277,539.45	972,685,328.27
1.2.1	Ажиллагчдад төлсөн	244,587,154.25	477,358,322.32
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	57,683,237.20	66,636,847.94
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	235,984,370.00	11,581,450.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	13,957,891.00	20,922,318.00
1.2.5	Түлш .шатахуун тээврийн хөлс.сэлбэг хэрэгсэлд төлсөн		262,602,321.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		474,496.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	36,064,887.00	133,109,573.01
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(11,596,856.45)	(439,139.26)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	20,520,000.00	1,243,894.58
2.1	Мөнгөн орлогын дүн	20,520,000.00	1,436,428.58
2.1.5	Бусдад олгосон зээл. Мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	20,520,000.00	1,436,428.58
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн	8,506,386.00	192,534.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,443,900.00	
2.2.5	Бусдад олгосон зээл. Урьдчилгаа	6,062,486.00	192,534.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	12,013,614.00	1,243,894.58
3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн		
3.1.1	Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн		
3.2.1	Зээл. Өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.4	Төлсөн ноогдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	416,757.55	804,755.32
6	Мөнгө.түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	416,755.55
7	Мөнгө.түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	416,755.00	1,221,510.87

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны		зөрүү	хувь
		төлөвлөгөө	гүйцэтгэл		
1	Нийт орлогын дүн	979,830,200.00	972,246,100.00	7,584,100.00	99.23
1.1	Үндсэн үйл ажиллагааны орлого /айл өрх аж ахуйн хогны төлбөр/	120,000,000.00	101,547,400.00	18,452,600.00	84.62
2.1	Татаас, санхүүжилтийн орлого	845,830,200.00	845,830,200.00	-	100.00
2.1.1	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ	689,985,000.00	689,985,000.00	-	100.00
2.1.2	Төвлөрсөн хогийн цэгүүдийн устгал, ариутгал, ашиглалтын үйлчилгээ	75,000,000.00	75,000,000.00	-	100.00
2.1.3	Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	80,845,200.00	80,845,200.00	-	100.00
3	Бусад орлого	14,000,000.00	24,868,500.00	(10,868,500.00)	177.63
4	Нийт зарлагын дүн	979,830,200.00	2,101,962,970.00	(1,122,132,770.00)	214.52
1	Цалин хөлс нэмэгдэл урамшуулал	456,824,400.00	473,687,615.00	(16,863,215.00)	103.69
2	АО-оос НД төлөх шимтгэл	66,239,500.00	66,636,847.00	(397,347.00)	100.60
3	Бичиг хэрэг	1,650,000.00	3,363,650.00	(1,713,650.00)	203.86
4	Гэрэл цахилгаан	-	236,514.00	(236,514.00)	-
5	Түлш халаалт	27,895,600.00	24,409,371.00	3,486,229.00	87.50
6	Тээвэр /шатахуун/	164,494,900.00	143,773,380.00	20,721,520.00	87.40
7	Шуудан холбоо, интернет	2,914,800.00	3,135,900.00	(221,100.00)	107.59
8	Цэвэр бохир ус	5,340,000.00	983,300.00	4,356,700.00	18.41
9	Дотоод албан томилолт	2,000,000.00	5,608,000.00	(3,608,000.00)	280.40
10	хөдөлмөр хамгааллын зардал	17,350,000.00	16,659,500.00	690,500.00	96.02
11	Нормын хувцас зөөлөн эдлэл	7,000,000.00	5,788,400.00	1,211,600.00	82.69
12	Сэлбэг хэрэгсэл /Урсгал засвар/	31,932,000.00	52,062,000.00	(20,130,000.00)	163.04
13	Ногоон байгууламжийн усалгаа арчилгаа, үйлчилгээ	33,291,000.00	32,825,300.00	465,700.00	98.60
14	Автозамын цэвэрлэгээ, үйлчилгээ	-	8,009,800.00	(8,009,800.00)	-
15	Тавилга, тоног төхөөрөмж	5,000,000.00	3,422,000.00	1,578,000.00	68.44
16	Төлбөр хураамж, бусад зардал	28,148,000.00	12,992,360.00	15,155,640.00	46.16
17	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	9,750,000.00	16,300,000.00	(6,550,000.00)	167.18
18	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	-	1,130,521,633.00	(1,130,521,633.00)	-
19	Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх	120,000,000.00	101,547,400.00	18,452,600.00	84.62

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь “Цэвэр хотын өнгө үзэмж болон ногоон байгууламжийг бий болгож, иргэдэд эрүүл аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон хог, хаягдлын үйлчилгээний үнэ тарифаар иргэн, аж ахуйн нэгж, төр төсвийн байгууллагад үйлчилгээ үзүүлэх, хог хаягдлыг тээвэрлэх, устгах боловсруулах ажил үйлчилгээ,
- Сумын өнгө үзэмжийг сайжруулах тохижилтын ажил үйлчилгээ эрхлэх,
- Сүхбаатар сумын нийтийн эзэмшлийн зам талбай, төв цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт, ургалтыг хариуцан ажиллах,
- Үйлдвэрийн газрын захирлын тушаалаар тогтоосон үнэ тарифын модны болон цэцгийн үрслэгээний суулгацыг худалдах, мод, цэцэг тарих, суулгах,
- Сүхбаатар сумын ногоон байгууламжийн үйлчилгээний төлөвлөлт, бодлогыг боловсруулах, менежментийг сайжруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхлэх,
- Ногоон байгууламж, байгаль орчны талаар баримтлах бодлого, хууль тогтоомж, хэтийн болон ойрын зорилтын дагуу сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал буюу төлөөлөн хэрэгжүүлэгч нь сумын Засаг дарга байх бөгөөд 100.0 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь Сүхбаатар сумын ИТХ-ын 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор байгуулагдсан байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх” 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д “ Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд Сүхбаатар сумын ИТХ, ЗДТГ, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч борлуулалтын орлого, хөрөнгө оруулалтын талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн

нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,041,127.6 мянган төгрөгөөр буюу 33.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	416,755.55	1,221,510.87	804,755.32
Авлага	15,478,407.00	19,976,453.00	4,498,046.00
Бусад санхүүгийн хөрөнгө	28,850,000.00	28,850,000.00	-
Бараа материал	52,500,580.00	72,921,353.00	20,420,773.00
Үндсэн хөрөнгө	2,996,959,462.86	1,930,108,284.38	(1,066,851,178.48)
Нийт хөрөнгийн дүн	3,094,205,205.41	2,053,077,601.25	(1,041,127,604.16)
Өр төлбөр	15,104,778.43	23,209,082.75	8,104,304.32
Татварын өр	2,704,171.48	9,798,872.23	7,094,700.75
НДШ-ийн өглөг	13,457,116.37	-	(13,457,116.37)
Богино хугацаат өр төлбөрийн нийт дүн	31,266,066.28	33,007,954.98	1,741,888.70
Эздийн өмчийн бусад хэсэг	3,987,720,109.39	3,987,720,109.39	-
Хуримтлагдсан ашиг/+, алдагдал/-/	(924,780,970.26)	(1,967,650,463.12)	(1,042,869,492.86)
Эздийн өмчийн нийт дүн	3,062,939,139.13	2,020,069,646.27	(1,042,869,492.86)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,094,205,205.41	2,053,077,601.25	(1,041,127,604.16)

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 19,976.5 мянган төгрөг болж 4,498.0 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны аудитаар өгөгдсөн актын төлбөр барагдаагүй тул авлагаар бүртгэснээс шалтгаалсан байна. Нийт авлагын 47.1 хувь буюу 9,415.9 мянган төгрөгийг 2012 онд үүсгэсэн айл өрх, аж ахуйн нэгжээс авах хогны төлбөрийн авлага эзэлж байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 72,921.4 мянган төгрөг болж 20,420.7 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдахад хураагдсан 1 удаагийн хамгаалалтын хэрэгсэл, хувцсыг аймгийн орон нутгийн өмчийн газраас үнэ төлбөргүйгээр хүлээлгэн өгснөөс шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,930,108.3 мянган төгрөг болж 1,066,851.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 931,0 мянган төгрөгөөр

камер худалдан авч, газарт байгуулсан 62,739.5 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг залруулж, тайлант онд 1,130,521.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцоноос шалтгаалжээ.

- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 33,007.9 мянган төгрөг болж 1,741.9 мянган төгрөгөөр өссөн нь НДШ-ийн өглөгийн 13,457.1 мянган төгрөгөөр буурч, хувь хүний орлогын албан татварын өглөг 7,094.7 мянган төгрөгөөр, өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн өглөг 4,000.0 мянган төгрөгөөр, халаалтын зардлын өглөг 4,104.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулж тайлант оны нийт орлого, зардлыг 964,830.2 мянган төгрөгөөр төсөвлөсөн байна.

Орлогыг дараах эх үүсвэрээс бүрдүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

- Айл өрх, аж ахуйн хог хаягдлын хураамж 120,000.0 мянган төгрөг,
- Нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, үйлчилгээний санхүүжилт 689,985.0 мянган төгрөг,
- Төвлөрсөн хогийн цэгүүдийн устгал, ариутгал, ашиглалтын үйлчилгээний санхүүжилт 60,000.0 мянган төгрөг,
- Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээний санхүүжилт 80,845.2 мянган төгрөг,
- Бусад орлого 14,000.0 мянган төгрөг зэрэг.

Тайлант онд Сүхбаатар сумын төсвийн тодотголоор 15,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмж олгосон бөгөөд орлогын гүйцэтгэлээр 972,246.1 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 0.8 хувь буюу 7,584.1 мянган төгрөгөөр тасалсан нь Сүхбаатар сумын хог, хаягдлын хураамжийн дансанд төвлөрүүлдэг орлого 18,452.6 мянган төгрөгөөр тасарсан, бусад орлого буюу төлбөрт үйлчилгээний орлого 3,468.5 мянган төгрөгөөр давж биелэн, Сүхбаатарын талбайн тохижилтод 7,400.0 мянган төгрөгийн хандивын орлого бүрдүүлснээс шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,101,962.9 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 1,122,132.7 мянган төгрөг буюу 14.5 хувиар хэтэрсэн нь / *нийт зардалд хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцож төлөвлөөгүй* / тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас голлон шалтгаалсан байна.

Тайлант онд 1,120,915.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь гал түймэр гарснаас автомашины сэлбэг хэрэгслийн зардал өссөн болон үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалтай холбоотой байна.

2023 оны 04 дүгээр сард тус байгууллагын автограшт гал гарснаас 3 автомашин шатаж, сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээнд 15,800.0 мянган төгрөгийн

зардал гарч, гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэхээр аймгийн Цагдаа, Прокурорын байгууллагад хандсан боловч гэмт хэргийн шинжтэй үйлдэл биш гэж үзэж, хохирлын хэмжээг тогтоогоогүй байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн насжилт өндөртэй авлагыг барагдуулах, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөх, шаардлага хангасан программ хангамж ашиглахтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 31 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 2,109,050.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 21,090.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж бичиг хэргийн зардлыг хэмнэсэн,
- Ажилчдад олгодог нормын хувцаснаас өөрөөр байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан аваагүй,
- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй,
- Байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь мэдээлбэл зохих 26 төрлийн 157 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

Хугацаа хоцроож мэдээлсэн:

- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт – 1, 5 сарын мэдээлэл,
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан,

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:

Шууд худалдан авах болон харьцуулалтын аргын босго үнээс давсан 164,494.9 мянган төгрөгийн шатахууны худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар бус НИК ХХК-тай шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална", 8 дугаар зүйлийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийн 1: "Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-70.0 сая төгрөг", 2: "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулж байх зөвлөмж хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн тус байгууллагын худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 124 дүгээр "Санхүүгийн тайланд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн бэлэн мөнгөний гүйлгээг байгууллагын бус нярвын хувийн харилцах дансаар дамжуулан гүйцэтгэж байсан зөрчлийг арилгаж, албан шаардлагыг 100 хувь биелүүлсэн. Тус байгууллагын захирлаар ажиллаж байсан Д.Ганцэцэг нь холбогдох албан тушаалтны шийдвэргүйгээр 2,115.6 мянган төгрөгийн урамшуулалт цалин авсан, хууль бусаар ажлаас халагдсан нь тогтоогдсон Ц.Ариунзулын ажилгүй байсан хугацааны 8,049.0 мянган төгрөгийн цалин хөлсийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосныг биелүүлэхээр Сэлэнгэ аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлж, санхүүгийн тайланд авлагаар тайлагнасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт	Биелэлт
----------	------------------------	---------

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	10,664.6	1	500.0	0.5
Албан шаардлага	1	16,500.0	1	16,500.0	100.0
Нийт дүн	1	27,164.6	1	17,000.0	62.5

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Үйлдвэрийн газар өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан ажиллах чадваргүй, үйлдвэрлэлийн үр дүнгээр алдагдал хүлээн ажиллаж байна. Цаашид үйлдвэрлэлийн удирдлага, менежментийг сайжруулах замаар үйлдвэрлэлийн үр дүнгээр ашиг хүртэх нөхцөл боломж бий эсэх, шаардлагатай бол бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх эсэх асуудлыг гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгаж, дүгнэлт өгөх нь зүйтэй.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 87,855.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

- Орлогын дэлгэрэнгүй тайланд орлогыг 24,868.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Газар эзэмших эрхэд 62,987.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”: 14.4.5: “бүх орлого”, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ын 5.5 дахь “Газрын өмчлөх, эзэмших болон ашиглах эрхийг бүртгэлд тусгахдаа дараах бичилт хийнэ. Газар өмчлөх эрхийг үнэлсэн дүнгээр биет хөрөнгөөр, эзэмших/ашиглах эрхийг биет бус хөрөнгөөр бүртгэнэ. Газар эзэмших болон ашиглах эрхтэй бол биет бус хөрөнгөөр бүртгэх бөгөөд цаашид элэгдүүлэхгүй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аудитаар нийт **27,868.5** мянган төгрөгийн зөрчил² илрүүлснээс 18,452.6 мянган төгрөгийн албан шаардлага, 9,415.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

1. Боловсруулж, батлуулсан 2023 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөвт төвлөрүүлэх хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөг **18,452.6** мянган төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “*Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан*

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

биелэлтийг хангах” гэсэн заалт болон сумын Засаг даргын баталсан “2023 оны үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө”-г зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлого зарлагын төлөвлөгөөг тооцоо судалгаан дээр үндэслэн бодитоор төлөвлөж, биелэлтийг ханган ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

1. Авлагын насжилт, барагдуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: 2012 онд айл өрх, аж ахуйн нэгжээс авах хогны төлбөрийг байгууллага, айл өрх 1 бүрээр бус бөөн дүнгээр тооцож, 9,415.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн бөгөөд уг авлагыг барагдуулах, шаардлагатай бол холбогдох байгууллага, албан тушаалтанд хандаж данс бүртгэлээс хасах талаар арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах”..., Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Олон жил болсон насжилт өндөртэй авлагын тооцоог хянах, дүн шинжилгээ хийх, барагдуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол холбогдох байгууллагуудад хандаж, данс бүртгэлээс хасах.

2. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой дараах зөрчил илэрсэн нь хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сулруулж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, бүртгэл тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 3.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Хүн тус бүрийн бичсэн шаардах хуудас, олгосон жагсаалт, хүлээн авсан хүний гарын үсэг зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр зөвхөн ХАБЭА-н инженерийн бөөн дүнгээр бичсэн шаардах хуудсыг үндэслэн ажилчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслийг олгож байна.
- Жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт болон шатахуун зарцуулалтын нормыг бүрэн хөтлөлгүйгээр ирсэн, явсан цагаар тооцож шатахууныг олгосон байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил, гүйлгээг гүйцэтгэж, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

3. Санхүүгийн программтай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй "Artlab " санхүүгийн программ нь Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу бүртгэлийн маягт болон мэдээллийг бүрэн боловсруулж, тайлагнах

шаардлагыг хангахгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалын 1-р хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага”-ын 1.3 “ журнал, ерөнхий данс, санхүүгийн тайланд тодруулга хийх боломжтой болон бүртгэлийн маягууд нь стандартын шаардлагыг хангасан байх”, 1.12 “ ... хөрөнгийн хөдөлгөөний мэдээ гаргах боломжтой байх”, 2.11 “ тайлан, мэдээллийг файл (XLS, TXT), принтерээр гаргах боломжтой байх ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд стандартын шаардлага хангасан программ хангамжийг ашиглах.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого дутуу тайлагнасан	1	24,868.5	1	24,868.5			1	24,868.5				
Газарт элэгдэл тооцсон	1	62,987.2			1	62,987.2	1	62,987.2				
Дүн	2	87,855.7	1	24,868.5	1	62,987.2	2	87,855.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төлөвлөсөн орлогыг дутуу төвлөрүүлсэн	1	18,452.6			1	18,452.6						
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэсэн	1	-			1	-						
Насжилт өндөртэй авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй.	1	9,415.9					1	9,415.9				

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй.	1	-				1	-				
Шаардлага хангахгүй программ хангамж ашигласан.	1	-				1	-				
Дүн	5	27,868.5			2	18,452.6	3	9,415.9			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлбэл зохих 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1				1			
Дүн	1				1			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1						1	
Дүн	1						1	
Нийт дүн	2						1	